

СУРАГЧДАД СУРАЛЦАХ АРГА БАРИЛ ЭЗЭМШҮҮЛЭХ НЬ

А.Загдаа УБДС-ийн тэнхимийн эрхлэгч, дэд эрдэмтэн

Сурагчдын амжилттай суралцах нэг үндсэн нөхцөл бол сайн уншиж чаддаг, хүмүүсийн яриаг зөв сонсож чаддаг, юмс үзэгдлийг ажиглаж чаддаг, ойлгосноо тэмдэглэж, сэргээн санаж ярьж чаддаг байх явдал юм. Унших чадвар, сонсох чадвар хоёр ялгаатай. Унших чадвар нь материалыг (ном, бичсэн хичээлээ) бие дааж уншаад ойлгох аргыг агуулдаг бол сонсох чадвар нь бэлэн хэлж өгч байгаа материалыг ойлгож авах явдал юм. Үүнээс үзвэл унших чадвар нь сонсох чадвараас илүү бүтээлч шинжтэй байна. Энэ хоёр чадварын төсөөтэй тал гэвэл аль аль нь хүлээн авч байгаа мэдээллээ өөрийн болгон ойлгож авахад чиглэсэн оюун ухааны үйл ажиллагаа байдагт оршино. Ном уншиж байгаа буюу багшийн ярихыг сонсож байгаа сурагч яригдаж байгаа зүйл дуусахаас өмнө түүний утга санааг түрүүлээд ойлгож чадаж байвал унших (сонсох) чадвартай болж байна гэж үзэж болно.

Хичээлийн материалыг хурдан унших, гол нь уншиж байгаа зүйлийн утгыг ойлгож түүний гол гол санааг олж, тэдгээрийг утга агуулгаар нь бүлэглэх, хооронд нь харьцуулах, ойдоо тогтоох, гарч байгаа үйл явдлыг санаандаа дүрслэн төсөөлөх гэх мэт оюун ухааны үйл ажиллагааг унших чадварт хамааруулж болно. Ийм учраас ойлгож уншихад зайлшгүй чухал оюун ухааны үйл ажиллагааны арга барилын тухай ярилцъя. Хийх ажлын зорилго, зорилтыг сайтар мэдэж байх нь сурах ажлын үр дүнд сайн нөлөөлнө. Зорилгоо ойлгох ажил багшийн өгсөн даалгавар, унших эх сэдвийн гарчиг, бодлого, дасгалын асуултад анализ хийхээс эхэлнэ. Сурагчид дасгал, даалгаврын асуулт, гарчгийг орхиод шууд уншиж, бодох, хийх ажилдаа орох явдал олонтоо ажиглагддаг. Энэ буруу. Оюун ухааны задлаг (анализ) ба нийлэг (синтез) хийх үйл ажиллагаа гарчигнаас эхэлнэ. Ер нь ном, сурах бичгийн гарчиг уншуулж, бүлэг хэсгүүдийг харьцуулж үзэх, тэдгээрийн хоорондох холбоог хэлж өгөх нь хүүхдэд нэгтгэн дүгнэх үйлдэл төлөвшихөд их ашигтайг мартаж болохгүй.

Уншиж байгаа буюу сонсож байгаа зүйлээ утга санаагаар нь бүлэглэж сургах нь туйлын чухал.

Үүний тулд хүүхэд унших материалын утга агуулгыг зөв бүлэглэж чадаж байгаа эсэхэд багш хяналт тавьж, тусалж байвал зохино.

Юмс, үзэгдлийг ажиглаж тэдгээрийн аль болох олон шинжийг нэрлүүлж, дараа нь тэдгээрээс гол ба гол бус шинж нь юу болохыг хүүхдээр ялгуулж бүлэглүүлж сургавал их сайн. Жишээ нь, “Ном” гэдэг ухагдахууны (юмны) шинжүүд гэвэл: зурагтай, зураггүй, хатуу зөөлөн хавтастай, зузаан нимгэн, бодлого дасгалтай асуулттай, шинэ сонин үлгэр домогтой, шинжлэх ухааны мэдлэгийн тухай өгүүлсэн, зохиогчтой, зохиогчгүй гэх мэт маш олон шинжтэй байна. Эдгээр шинжийн ихэнх нь гол бус шинж байна. Харин “хүн төрөлхтний хуримтлуулсан мэдлэг, мэдээлэл агуулсан” зэрэг шинжийг нэгтгэн дүгнэж ерөнхийлж байж сая дээрх гол шинжийг хэлж чадах юм. Ийнхүү сурагчид гол бус шинж бол зарим номд л байна, харин гол шинж бол номын бүх төрөлд нийтлэг байх зүйл юм гэж дүгнэлт хийж чадсан байх ёстой. Сурах хөдөлмөр дээр юмс үзэгдлийг хооронд нь харьцуулж сургахад их анхаарвал зохино. Нэг төрлийн хэд хэдэн зүйлийг харьцуулан жишиж ялгаатай ба нийтлэг ерөнхий шинжийг олуулна. Нэг төрөл зүйлийн ялгаатай шинж нь гол бус шинж, харин нийтлэг шинж нь ихэвчлэн гол шинж болдог гэдгийг хүүхдэд ойлгуулах хэрэгтэй. Нэг төрөл зүйлийн нийтлэг ерөнхий шинжийг олох нь хүүхдүүдэд нэлээд бэрхшээлтэй байдаг юм. Жишээ нь, төрөл бүрийн гүрвэлийг буюу мөн газар уснаа амьдрагч “хоёр нутагтан” амьтдыг харьцуулж ялгаатай болон нийтлэг шинжийг олуулах жишээтэй юм. Мөн боолын нийгмийн хэд хэдэн улсуудыг харьцуулан үзэж тэдгээрийн аж ахуй, соёл, төрийн зохион байгуулалтын ялгаатай шинж, мөн улс бүрд нийтлэг байдаг боол эзэмших ёсыг олж тогтоох гэх мэт.

Аливаа үзэгдэл юмсын олон талаас нь авч үзэх арга барил сургалтад их хэрэг болдог. Жишээ нь, БНМАУ-ыг газарзүйн байршлын талаас нь, физик газарзүйн шинжээр нь эдийн засгийн хөгжлийн талаас нь, хүн амын байдлаас нь, олон улсын харилцааны талаас нь, нийгмийн бүтцийн талаас нь гэх мэт авч үзэж болно. Энэ мэт аливаа юмны

(энгийн зүйлээс эхэлбэл сайн) олон талаас нь хүүхдээр яриулж байвал зохино. Юмс үзэгдлийг олон талаас нь авч үзэж сурвал судалж байгаа материалын гол зүйл, дотоод холбоо хамаарлыг олж илрүүлж чаддаг болно. Ном, сурах бичигт гол зүйлийг тод хар үсгээр бичих, доогуур нь буюу хүрээлж зурах зэргээр онцолсон байдаг юм. Мөн сурагчийн хичээлийн дэвтэрт гол зүйлийг заавал бичиж түүнийг улаан, хөх өнгөөр ялгаж зурж тодруулсан байх шаардлагатай байдаг. Энэ нь сурагчдад гол зүйлийг тодруулан хийсвэрлэхэд тус болдог. Хичээлийн материалын гол зүйл нь дүрэм, томьёо, онолын дүгнэлт, хууль, зүй тогтол, үзэл санаа, зарим шинэ ухагдахуун (нэр томьёо) зэргээр илэрч байдгийг анхаарвал зохино. Хичээлийн материалд энэ гол зүйлээ үндэслэж баталж өгөхөд чиглэгдсэн жишээ баримт болон урьд өмнө үзээд өнгөрсөн онолын мэдлэг, зураг, баримт сэлт зэрэг туслах чанарын материал их байдаг. Энэ нь гол зүйлийг ойлгож авахад тус дөхөм болдог юм. Иймээс шинэ, хуучин онолын мэдлэг, жишээ баримт, туслах чанарын материал зэргийг ялгаж байх нь сурах арга барилын чухал хэсэг болдог.

Ном, сурах бичгийн зураг, схем, диаграмм, хүснэгт, график нь гол зүйлийг ойлгоход их тустай зүйл. Иймд тэдгээрийг сайн ажиглаж, зарим зүйлийг тусгайлан зурж үзэх хэрэг гардаг. Ер нь хичээлийн материалыг ойлгохдоо гол зүйлээсээ эхэлбэл зохино. Гол зүйлийг уншаад ойлгохгүй бол туслах чанарын материалыг ашиглах ёстой. Тэгэхдээ туслах чанарын материалыг ойлгоод шууд гол зүйл уруугаа дахин дахин эргэж унших зэргээр аль болох цөөн тооны туслах материал үзэж гол зүйлээ ойлгож явахыг хичээж байх шаардлагатай. Юмс үзэгдлийг өөрийг нь буюу түүнийг дүрсэлсэн зургийг харж байгаад түүний бүтэц хэсэг, шинж тэмдгүүдийг задлан үзэх, нэгтгэн сэтгэх, олон талаас нь авч үзэж ярилцах, дүгнэлт хийх чадварыг ажиглах чадвар гэж бид үздэг.

Карт, зураг, схем, диаграмм, хүснэгтийг зөвхөн ажиглаад орхих биш харин түүнийг хүүхдийн ой санаанд нь сайн “харагдтал” төлөөлүүлж сургах нь тэдний дүрслэн бодох чадварыг хөгжүүлдэг юм. Үүний хамтад эх сэдэвт бичигдсэн буюу хүний ярих зүйлд гарч байгаа үзэгдэл юмс, үйл явдлыг мөн л санаанд “харагдтал”, сайн төсөөлүүлж бодуулж байх нь чухал юм. Үүний дараагийн шат нь төсөөлснөө өөрчилж хувиргах дасгал, тухайлбал зарим хэсгийг санаандаа хөдөлгөх, шилжүүлэх, ихэсгэх багасгах, эргүүлэх, давхцуулах, салгах, нийлүүлэх дасгалыг хийж сургана. Төсөөлсөн

зүйлийн аль нэг хэсэг, эд ангийг өөрчлөхөд бусад хэсэг яаж өөрчлөгдөхийг сурагчдаар яриулж байвал сайн. Хэл хэдэн төстэй юмыг санаандаа дүрсэлж байгаад хооронд нь харьцуулж чаддаг байх, улмаар тэдгээр юмыг санаандаа хувиргаж байгаад хооронд нь харьцуулан жишиж сурах явдал маш чухал. Юмыг биеэр нь буюу түүний зургийг үзэж байгаад хооронд нь харьцуулан жишихтэй адилаар үүнийг төвөггүй хийж сурвал бүр сайн. Энэ нь хүүхдийн дүрээр сэтгэх сэтгэхүйн хөгжлийн нэлээд дээд шат учир лекц яриаг сайн ойлгож авахад тус болно. Юмсын хэмжээ, орон зайн байршил, бүтэц хэсгийг хувиргах, түүнийг хязгааргүй үргэлжлүүлэх (жишээ нь, шулуун, хавтгайг хязгааргүй болгон төсөөлөх г.м) үйлдлийг санаандаа чөлөөтэй хийж энэ үед тэдгээрийн хоорондох хамаарал хэрхэн өөрчлөгдөж байгааг сэтгүүлж дүгнэлт хийлгэх шаардлага математикийн хичээл дээр их гардаг юм. Мөн аливаа юмны өнгөрсөн ба одоогийн байдал, ирээдүйн төлөвийг үүсэл хөгжил, өөрчлөлт хөдөлгөөнд нь авч үзэх сэтгэлгээний арга барил байгаль иийгмийн ухааны аль ч хичээлийг ойлгоход их хэрэглэгдэнэ. Иймд урьд нь ямар байв, одоо ямар болов гэдгийг ямагт харьцуулж ярилцаж байвал сайн. Хүн зөвхөн санаандаа дүрслэгдэж байгаа зүйлд тулгуурлаж сэтгэдэггүй, харин гол нь ухагдахуунаар сэтгэдэг юм. Аливаа юмс үзэгдэл, тэдгээрийн шинж чанар, байдлыг заасан үг (нэр томьёо) бүхний цаана ухагдахуун байдаг. Өөрөөр хэлбэл, ухагдахуун үг, нэр томьёогоор илэрнэ. Ухагдахуун гэдэг бол уул юмс үзэгдэл хамгийн гол шинжээрээ хүний ухамсарт тусгагдсан тусгал юм. Иймд юм болгон дээр хамгийн гол шинжийг хүүхдээр хэлүүлэхийг хичээж байвал зохино. Жишээ нь, сандлын гол шинж “хүн суух тавцантай”, ширээнийх бол “дээр нь ажиллах тавцантай”, үндэстэн гэдэг ухагдахууны гол шинж нь “эдийн засаг, соёл, хэл, зан заншлын нийтлэг хэлхээ холооо бүхий” гэх мэтээр ямар ч ухагдахуун өөрийн агуулгатай байна. Жишээлбэл, гурвалжин гэж юу вэ? График гэж юу вэ? Өндөрлөг гэж юу вэ? Анги гэж юу вэ? өгүүлбэрийн гишүүн гэж юу вэ? Хүч гэж юу вэ? гэх мэт сурагчдын заалгаж байгаа хичээл бүхэн үй олон ухагдахууны системийг өөртөө агуулж байдаг. Сурагч тэдгээр ухагдахууны гол шинжийг ойлгож төрөл ухагдахууны хоорондох холбоог мэдэж байх ёстой. Бас гол ба гол бус шинжүүдийг хооронд нь ялгаж, ямар учраас энэ шинж гол, гол бус гэдэгт дүгнэлт хийж чаддаг байх ёстой.

Ухагдахууныг өргөтгөх жишээ нь хонь, ямаа, таван хошуу мал -гэрийн тэжээмэл амьтад гэх мэт

болон юмс үзэгдлийг (хонь бол) ухагдахуунд (мал мөн) хамааруулах, мөн үүний урвуу үйлдэл болох ухагдахууны хүрээг явцууруулах, жишээ нь, ном-сурах бичиг-цагаан толгой гэх мэт үйлдэл хийлгэж, тэдгээрийг харьцуулан сэтгүүлж ухагдахуун тус бүрийн хэмжээ (багтаамж)-г ойлгуулах хэрэгтэй юм. Мөн ухагдахууныг тодорхой ухагдахуун, хийсвэр ухагдахуун, нэгж ба ерөнхий ухагдахуун аль нь болохыг ялгуулах дасгалыг хичээл дээр хийлгэж байвал зохино. Ялангуяа, юмс үзэгдлийн дотоод шинж, гол холбоо, хамаарал, харилцааг илэрхийлсэн ерөнхий, хийсвэр ухагдахууныг таниулахад онцгой анхаарах хэрэгтэй.

Ухагдахуун, категори нь гол шинжээрээ тодорхойлогддог, гол шинж нь түүний агуулга гэдгийг мэдүүлж тодорхойлолтын логик бүтцийг ойлгуулж, энэ үндсэн дээр хэд хэдэн тодорхойлолтыг хооронд нь харьцуулан жишүүлж түүний логик бүтцийг харуулах ба энгийн хялбар ухагдахууныг сурагчдаар бие даалгаж тодорхойлуулах дасгал хийлгэж байвал зохино. Ухагдахууныг “төрөл шинж, хэлбэрийн ялгаагаар тодорхойлох”, “агуулга, бүтэц хэсгийг тоочих” аргаар тодорхойлох, мөн “үүсэх аргаар нь” тодорхойлох гэх мэт аргуудын логик талыг сурагчдад мэдрүүлбэл зохино. Үүний тулд багш заадаг хичээлийнхээ бүх тодорхойлолтыг тоо ёсоор ялгаж аваад аль хэсэг ухагдахуун ямар аргаар тодорхойлогдож байгааг өөрөө сайн мэдэж авбал зохино. Юмс үзэгдлийг ангилах арга барил сургалтад элбэг тохиолдоно. Харамсалтай нь сурагчид ангиллаа мэдээд, харин ангилах арга мэдэхгүй байх нь олонтой байна. Иймд ангиллын үндэс буюу ангилал хийх шинжийг гол болгох хэрэгтэй. Жишээ нь, өгүүлбэрийг хүүрнэх, асуух, захирах өгүүлбэр гэж ангилж байгаагийн үндэс (шинж) нь зорилго, аялга юм.

Хичээлийн материалыг мартахааргүй ойдоо сайн тогтоох арга барил сурагчдад туйлаас эрхэм. Юмыг шууд цээжлэн тогтоох шаардлага ч хичээл дээр нь гардаг. Уншиж байгаа буюу сонсож байгаа материалаа утгачлан тогтоож сургах нь чухал. Материалыг хэсэг хэсэг болгон тогтоовол амар байдаг юм. Үүний тулд тогтоох гэж байгаа материалаа утга санаагаар нь бүлэглэж товчлон бичихээс эхэлбэл зохино. Мөн утга санаагаар нь бүлэглэсэн хэсэг тус бүрт тохирох гарчиг олж тавивал хожим тэр гарчгаа сэргээн санаж байгаад ярихад амар байдаг юм. Бага хэмжээний материалыг санаандаа төлөвлөж тогтоох арга барилыг дунд, ахлах ангийн сурагчид эзэмшсэн байх шаардлагатай.

Сурагчдыг бичих буюу ярих зүйлээ

төлөвлөхдөө ерөнхийгөөс арай тодорхой зүйлд шилжихдээ нэг, хоёр-I, II,-I, 2-а. б.-= (зураас) гэх мэт нумераци хэрэглэн системтэй задлан бичиж тэмдэглэж сургавал зохино. Бичгийн ажлын үндэс хэлбэрүүд цээж бичиг, найруулан бичиг, зохион бичлэгээс гадна санал, шүүмж, зарлал, өргөдөл, мэдээ, найруулал, илтгэл, сонсгол, сэдэв, конспект, төлөвлөгөө, ишлэл, тэмдэглэл, реферат зэрэг бичлэгийн төрөлтэй танилцаж, тэдгээрийг бие дааж хийж сурсан байх шаардлага дунд ахлах ангийн сурагчдад тавигдана. Мөн өөрийн болон нөхдийн хийсэн бичгийн ажилд дор дурсан санамжийг баримталж сурсан байх хэрэгтэй. Үүнд, бичих төлөвлөгөө зохиох, сэдвийн агуулгыг бүхэлд нь болон түүний үг, өгүүлбэр бүрийн утга санааг сайтар эргэцүүлэн бодох санаагаа оновчтой гаргах уран үг, өгүүлбэрийг сонгож авах, ижил үг өгүүлбэрийг давтан хэрэглэхээс зайлсхийх, бичиж байгаа зүйлдээ өөрөө хэрхэн хандаж байгаагаа гаргаж бичих, дүгнэлт хийх гэх мэт.

Бичгийн ажлаа дуусаад гол санаа бүрэн гарсан эсэх, илүү дутуу, давхардсан санаа байгаа эсэх, бичгийн арга стиль, санаагаа уран тод гаргаж чадсан эсэхээ шалгадаг хэвшил тогтооход ихээхэн анхаарах хэрэгтэй. Мөн яриа лекцэд сууж байхдаа түүний гол санааг тэмдэглэлийн дэвтэртээ товчхон тэмдэглэж авдаг, тэмдэглэсэн зүйлээ хичээлийн конспект, дэвтрийн аль холбогдох хэсэгт нэмж бичдэг байвал маш сайн хэвшил болохсон билээ.

Хичээл дээр бодлогын нөхцөл, асуудалд анализ хийх, тоог цээжээр нэмэх хасах, үржүүлэх хуваах үйлдлийг олон хийлгэж, нийлбэр ялгаврыг квадратын томъёог цээжээр тоо бодоход ашигладаг болгох, мөн бодлогын хариуг ойролцоогоор урьдчилан баримжаалж гаргах, асуудлын хариу, эцсийн үр дүнг таамаглах дасгалыг хүүхдийн сайн мэдэх материал дээр хүүхдийг орон зай, зүг чиг, юмсын байршлыг санаандаа баримжаалах, цаг хугацааг ойролцоо төсөөлөх, юмсын хэмжээ, хол ойрын зайг хараад (сонсоод) баримжаалж чаддаг болгоход анхаарч, энэ талаар төрөл бүрийн уралдаан зохиож болно. Сурагчдыг номтой ажиллуулж сургахад хичээлээс гадуур зохиох олон төрлийн ажлыг өргөн ашиглах хэрэгтэй. Жишээ нь, “Номыг (сурах бичгээ) хэн сайн мэдэх вэ?” гэдэг уралдаан тэмцээн зохино.

Ном сурах бичгийн бүтэн, тухайлбал, зохиогч, редактор номын нэр, шифр, аннотаци, өмнөх ба төгсгөлийн үг, гарчиг, үндсэн ба туслах материал, зураг, схем, дасгал, хяналтын асуулт зэргийг ялгуулж, ач холбогдлыг тайлбарлуулна. 5-8 номын жагсаалтыг зохих журмын дагуу бичүүлж шалгаруулах, үүнд, ном буюу зохиогчийн нэрээр

цагаан толгойн үсгийн дарааллыг баримтлан номын жагсаалт гаргах, номын нэрийг зохиогч номын нэр (хэрэв зохиогчгүй бол редактор) хэвлэлийн газар, хэвлэгдсэн он гэсэн дарааллаар бичүүлнэ. Мөн энэ маягаар сэтгүүлийн өгүүллийн нэрийг зохих журмын дагуу бичүүлэх ажил хийлгэж болно.

Сонин, сэтгүүлийн тэргүүн өгүүлэл, дагавар өгүүлэл, гадаад мэдээ, сурвалжлага, нүүр булан гэж юу болохыг зөв тайлбарлуулж шалгаруулна.

Номын каталоги ашиглан захиалга бичиж ном авах уралдаан зохиож болно. Мөн толь бичгээс олох гэсэн үгээ аль болох хурдан олуулж шалгаруулж болно.

Дунд, ахлах ангийн сурагчдын дунд тоо баримтаар график, босоо ба дугуй диаграмм зохиолгох, уншсан номдоо (энгийн дэлгэрэнгүй) төлөвлөгөө зохиох, уншсан эх сэдвээс хамгийн гол үг, өгүүлбэрийг олуулах, тохирох оновчтой гарчиг шалгаруулах ба ахлах ангийн сурагчдын дунд тодорхой сэдвээр эх зохиолоос ишлэл авсан зүүлт, дүгнэлт, номын жагсаалт бүхий товчлол, рефератын уралдаан зарлах түүнийг дүгнэхдээ самбар үзэсгэлэн гаргаж шалгаруулж болно.

Дээр дурдсан ажлын аль нэг хэсгийг янз бүрийн сэдэвтэй үдэшлэг, өглөөлөг, АСТ зэргийн хөтөлбөрт оруулан урьдаас сайтар бэлтгэлтэй явуулбал сайн.

Сурагчдын хичээлийн дэвтрийг шалгаруулахдаа цэвэр нямбай байдал, бичгийн хэв маягийг ихэвчлэн харж шалгаруулж байна. Үүний зэрэгцээ, ялангуяа дунд, ахлах ангид бичсэн зүйлдээ догол мөр гаргах буюу мөр орхиж тусгаарласан, нумераци хэрэглэн агуулгыг системчилсэн, доогуур нь буюу хажуу талбайд (тайлбар бичсэн) зурж тодруулсан, өнгө ялгаж зурах буюу хүрээлж онцгойлсон, янз бүрийн тэмдэг, ялангуяа Лениний конспектод тохиолддог тэмдэглэлийг ашиглаж анализ хийсэн, онолын үндэслэл, жишээ баримт, баталгаа дүгнэлтийг ялгаж тэмдэглэсэн эсэх зэргийг харж хичээлийн дэвтэр (конспект)-ийг шалгаруулж байвал зохино.

Сурган хүмүүжүүлэх сэтгүүл № 5/1987